

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 2 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулсан зохицуулах, **зохион байгуулах**, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

#### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

4.1.3.“осол” гэж **уул уурхай**, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоог төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4.“гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5.“аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.6.“эмзэг байдал” гэж **аюулт үзэгдэл, осолд** хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг;

4.1.7.“гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусlamж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг;

4.1.8.“гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.9.“гамшгийн зарлан мэдээлэл” гэж олон нийтэд хүргэх дохио, сээрэмжлүүлэх мэдээллийг;

4.1.10.“эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусlamж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11.“голомтын бүс” гэж гамшиг, аюул, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон эсхүл шууд эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

4.1.12.“нэрвэгдэгсэд” гэж гамшиг, аюулын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэдийг;

4.1.13.“гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусlamж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;

4.1.14.“гамшгийн хор үршиг” гэж гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэrsэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг;

4.1.15.“гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-т заасан үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг;

4.1.16.“хойшлуулшгүй сэргээн босгох” гэж гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг;

4.1.17.“мэргэжлийн анги” гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг;

4.1.18.“сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг;

**4.1.19.“гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой**

**хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;**

**4.1.20.”гамшгаас урьдчилан сэргийлэх” гэж гэж аюулт үзэгдэл, ослын сөрөг үр дагавраас зайлсхийх, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг;**

**4.1.21.“хүмүүнлэгийн тусламж” гэж иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг;**

**4.1.22.“хорио цээрийн дэглэм” гэж цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, таслан зогсоох зорилгоор халдвартасан, халдварт тээгч, халдвартасан байж болзошгүй сэжиг бүхий болон тэдгээрийн харьцагч, хавьтагч хүн, мал, амьтан, эд материалыг тусгай нөхцөлд тогтоосон хугацаагаар бусдаас тусгаарлах, эмчлэх, сувилах, хяналт-ажиглалтад байлгахыг;**

**4.1.23.“хязгаарлалтын дэглэм” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн, хуулийн этгээд, байгууллагын үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг;**

**4.1.24.“бэлэн байдал” гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг.**

## **5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим**

5.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1.хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;

5.1.2.мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;

5.1.3.шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;

5.1.4.өмчийн хэлбэрийг үл харгалзах;

5.1.5.иргэдийн оролцоонд тулгуурлах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

## **6 дугаар зүйл. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа**

**6.1.Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлах бөгөөд дараахь төрөлтэй байна:**

6.1.1.гамшгийн эрсдэлийг үнэлэх;

6.1.2.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;

- 6.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах;
- 6.1.4.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- 6.1.5.гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- 6.1.6.гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах;**
- 6.1.7.гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

## **7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх**

**7.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.**

**7.2.Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.**

7.3.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь шаардлагыг хангасан хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоно:

7.3.1.эрсдэлийн үнэлгээний шинжээчийн бүрэлдэхүүн нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх;

7.3.2.шаардлагатай судалгаа, шинжилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

7.3.3.гамшгийн эрсдэлийн үнэлгээнд шаардагдах мэдээ, баримт, өгөгдөл бүхий мэдээллийн сантай байх;

7.3.4.гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх тогтсон арга, аргачлалтай байх;

### **7.3.5.хуульд заасан улсын тэмдэгтийн хураамж төлсөн байх.**

7.4.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

7.5.Онцгой байдлын ~~асуудал эрхэлсэн төрийн захиргааны~~ байгууллага гамшгийн эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллана.

7.6.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 7.1-д заасан байгууллага өөрөө хариуцна.

## **8 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх**

**8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.**

8.2.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

8.3.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## 9 дүгээр зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах

9.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан **засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж**, байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна:

9.1.1.болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах;

9.1.2.барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах;

9.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.4.гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх;

9.1.5.хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.

**9.2.“Бүтцийн арга хэмжээ” гэж барилга байгууламж, объект, зам, гүүр, далан болон бусад дэд бүтцийн аюулгүй, гамшигт тэсвэртэй байдлыг хангах арга хэмжээг ойлгоно.**

9.3.“Бүтцийн бус арга хэмжээ” гэж хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах болон бусад арга хэмжээг ойлгоно.

## 10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

### 10.1.Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараахь зэрэгтэй байна:

10.1.1.өдөр тутмын бэлэн байдал;

10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал;

10.1.3.бүх нийтийн бэлэн байдал.

10.2.Гамшгийн бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын дарга батална.

10.3.Өдөр тутмын бэлэн байдлын үед дараахь арга хэмжээг авна:

10.3.1.~~нутаг давсгэр, үйлдвэрлэлийн зэрчмаар~~ гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;

10.3.2.харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах;

10.3.3.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

10.3.4.гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;

10.3.5.гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;

10.3.6.гамшигийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах.

**10.3.7.Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах.**

10.4.Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3 дахь хэсэгт зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.4.1.гамшигийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх;

10.4.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх;

10.4.3.гамшигийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх;

10.4.4.хорио цээр, **хязгаарлалтын** дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшигийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;

10.4.5.гамшигийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх.

**10.4.6.соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;**

10.4.7.харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах;

10.4.8.голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах;

10.4.9.нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;

10.4.10.төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх;

10.4.11.улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах;

10.4.12.стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих;

10.4.13.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээ дэх гамшигийн талаарх илт худал мэдээлэл нь гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд ноцтой саад учруулахаар бол тухайн мэдээллийн тархалтыг бууруулах,

зогсоох арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авах;

10.4.14.эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;

10.4.15.гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх;

10.4.16.химиин хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох.

10.4.17.зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшигаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх.

10.5.Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.

~~10.6.Засаг захиргаа, нутаг довсгорийн хэд хэдэн нэгжид үүссэн голомтын бусад эрэн жайх, аврах, хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж дараахь арга хэмжээг авна:~~

~~10.6.1.харилцаа холбоо, эрчим хүч, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах;~~

~~10.6.2.гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.~~

10.7.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг бухэлд нь хэрэгжүүлнэ.

10.8.Энэ хуулийн 10.4.2-т заасан ажлын тусгай горимоор ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10.9.Энэ хуулийн 10.4-т заасны дагуу гарах аливаа шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд доор дурдсан шаардлагыг нэг мөр хангана:

10.9.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх;

10.9.2.үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх;

10.9.3.энэ хуулийн 10.9.2-т заасан зорилгод хүрэхэд зайлшгүй, тухайн нөхцөлд тохирсон, тодорхой хүрээ, хугацаатай байх;

10.9.4.хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх.

**10.10.Гамшгаас хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тухайн нөхцөлд тохируулан хамгийн бага хязгаарласан байна.**

**10.11.Монгол Улсын Их Хурал нь энэ хуулийн 10.4-т заасны дагуу Засгийн газраас гарах шийдвэр Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн эсэхэд тогтмол хяналт тавина.**

## **11 дүгээр зүйл.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх**

**11.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хөр уршгийг орилгах, жойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шат дараатай зөхион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 11.3-т заасан албан тушаалтан холбогдох шийдвэрийн дагуу өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ.**

**11.2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ.**

**11.2.1.энэ хуулийн 11.2-т заасан “бүрэн” гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээдийг бүхэлд нь, “хэсэгчилсэн” гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим хэсэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэд, хуулийн этгээдийн тодорхой хэсгийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхийг ойлгоно.**

**11.3.Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийг дараахь албан тушаалтан гаргана:**

**11.3.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Онцгой комиссын дарга;**

**11.3.2.хоёр буюу түүнээс дээш сүм, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Онцгой комиссын даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга;**

**11.3.3.улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар;**

**11.3.4.шаардлагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга.**

**11.4.Энэ хуулийн 11.3-т заасан албан тушаалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналд нутаг дэвсгэрээр дамжин тархсан, бус нутгийг хамарсан, хамарч болжошгүй гамшгийн цагийн байдлын үүлгээ, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэлийг тусгаж шийдвэрийн тослийг хавсаргана.**

**11.5.Энэ хуулийн 13.3.1-д заасан сургалтын үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт тур шилжүүлж болно.**

**11.6.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан, ~~өсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан~~ бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.**

## **12 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх**

12.1.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.

12.2.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална.

12.3.Гамшгаас хамгаалах **болон гол түймрийн** улсын хяналтын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна.

### **13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах**

13.1.Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сургаж дадлагажуулахад чиглэнэ.

13.2.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь ангиллаар явуулна:

13.2.1.удирдах албан тушаалтны;

13.2.2.онцгой байдлын байгууллагын;

13.2.3.оюутан, сургач, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн;

13.2.4.төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны;

13.2.5.гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн;

13.2.6.иргэний.

13.3.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь байгууллага, албан тушаалтан зохион байгуулна:

13.3.1.онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтны сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

13.3.2.орон нутгийн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан, цэргийн албыг биеэр дүйцүүлэн алба хааж байгаа иргэний сургалтыг орон нутгийн онцгой байдлын байгууллага;

13.3.3.сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга;

13.3.4.иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга;

13.3.5.онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сургалтыг тухайн нэгжийн дарга;

13.3.6.оюутан, сургач, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага;

13.3.7.хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан.

13.4.Энэ зүйлийн 13.3.1-д заасан сургалтыг 2 жилд нэг удаа, 13.3.2, 13.3.3, 13.3.4, 13.3.5, 13.3.7-д заасан сургалтыг жил бүр зохион байгуулна.

13.5.Энэ хуулийн 13.2-д заасан сургалтыг зохион байгуулахад Монголын улаан загалмай нийгэмлэг эрхлэх асуудлынхаа хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

## **14 дүгээр зүйл. Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх**

14.1.Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаанд ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

14.2.Гамшгийн мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

14.2.1.гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл;

14.2.2.гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл;

14.2.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ;

14.2.4.бусад мэдээлэл.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАМШГИЙН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **15 дугаар зүйл. Гамшгийн үеийн үйл ажиллагаа**

15.1.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн үйл ажиллагаа дараахь арга хэмжээнээс бүрдэнэ:

15.1.1.гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах;

15.1.2.голомтын бүсийг тогтоох;

15.1.3.эрэн хайх, аврах;

15.1.4.хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх;

15.1.5.гамшгийн хор уршгийг арилгах.

15.2.Гамшгийн үеийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулна.

15.3.Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **16 дугаар зүйл.Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах**

16.1.Гамшиг болон аюулын дохио, сээрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.

16.2.Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцаан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.

16.3.Гамшиг болон аюулын дохио, сээрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.

16.4.Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын **болон төрийн тусгай чиг үүрэг бүхий** байгууллага гүйцэтгэнэ.

16.5.Гамшигийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.

## 17 дугаар зүйл.Голомтын бүс тогтоох

17.1.Голомтын бүсийг доор дурдсан албан тушаалтан тогтооно:

17.1.1.аймаг, нийслэл, сүм, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор үршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;

17.1.2.хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэр болон улсын онц чухал объектод онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар.

**17.2.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах журмыг Засгийн газар батална.**

**17.3.Голомтын бүсэд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тухайн шатны онцгой байдлын байгууллага удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.**

## 18 дугаар зүйл.Эрэн хайх, аврах

18.1.Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ.

18.2.Шуурхай бүлгийн удирдагч онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

18.3.Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ.

18.4.Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай үзүүлэх үүрэгтэй.

18.5.Энэ хуулийн 18.1-т заасан томилгоот шуурхай бүлгийн ажиллах журам, зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

## 19 дүгээр зүйл. Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх

19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.

19.2.Энэ хуулийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.

**19.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд нь түр цугларах аюулгүйн талбайтай байна.**

## **20 дугаар зүйл.Гамшгийн хор уршгийг арилгах**

20.1.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өөрөө, эсхүл үүссэн нөхцөл байдлыг харгалзан онцгой байдлын байгууллага мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд шаардлагатай тохиолдолд үүссэн хохирол, хэрэгцээнд тулгуурлан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

20.3.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

20.4.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА**

### **21 дүгээр зүйл. Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа**

21.1.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа дараах чиглэлтэй байна:

21.1.1.нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах;

21.1.2.дэд бүтцийг сэргээн босгох.

21.2.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг улсын хэмжээнд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

**21.3.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон гадаад улсын, эсхүл олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусlamжийг авч болно.**

## **ТАВДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА**

### **22 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт**

22.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна.

22.2.Улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөл /цаашид “Үндэсний болон орон нутгийн зөвлөл” гэх/-ийг байгуулна.

**22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион**

байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

22.4.Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулна.

22.5.Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бүс байна.

22.6.Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох төрийн захиргааны бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бүс Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.

22.7.Сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж болно.

22.8.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна.

22.9.Үндэсний зөвлөл, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, гамшгаас хамгаалах улсын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн ангийн ажиллах дүрмийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

## **23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага**

23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

23.2.Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд, орон нутгийн зөвлөлийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга тэргүүлнэ.

23.3.Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

23.4.Улсын онцгой комиссын орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн онцгой комиссын орлогч дарга нь орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, сумын онцгой комиссын орлогч дарга нь тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.

## **24 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл**

24.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, эрэлч нохой,

гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, түүний объект, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал байна.

24.2.Мэргэжлийн ангийг Монгол Улсын харьят, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд цэргийн жинхэнэ алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, өрх толгойлсон эх /эцэг/ хамаарахгүй.

24.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт хүч болон ажиллана.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ**

### **25 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

25.1.Үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед Монгол Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль бусад шийдвэрийг гаргана.

25.2.Монгол Улсын Их Хурал гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг тодорхойлно.

### **25<sup>1</sup> дүгээр зүйл.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрх**

25<sup>1</sup>.1.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед холбогдох асуудлыг шуурхай хэлэлцэж, Улсын Их Хурал, Засгийн газарт чиглэл, зөвлөмж өгөх.

### **26 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

26.1.Монгол Улсын Засгийн газар гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, төсөл, хөтөлбөр, дүрэм, журмыг батлах;

26.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлах, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг тогтоох;

26.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах;

26.1.4.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах шийдвэр гаргах;

26.1.5.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх;

26.1.6.гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах;

**26.1.7.Улсын онцгой комиссын саналын дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох, холбогдох хөрөнгийг шийдвэрлэх;**

**27.1.8.Улсын онцгой комиссын саналыг үндэслэн шаардлагатай тохиолдолд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хуульд заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг түр хориглоно.**

## **27 дугаар зүйл. Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх**

**27.1.Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

**27.1.1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх;**

**27.1.2.гамшгийн дараахь сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах;**

**27.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах;**

**27.1.4.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх;**

**27.1.5.орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах.**

**27.2.Орон нутгийн зөвлөл энэ хуулийн 27.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.**

## **27<sup>1</sup>дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх**

**27<sup>1</sup>.1.Улсын онцгой комисс гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

**27<sup>1</sup>.1.1.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих;**

**27<sup>1</sup>.1.2.гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд энэ хуулийн 10.4, 10.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих;**

**27<sup>1</sup>.1.3.гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох;**

**27<sup>1</sup>.1.4.гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, тушаал, албан даалгавар гаргах;**

**27<sup>1</sup>.1.5.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Засгийн газарт танилцуулах;**

**27<sup>1</sup>.1.6.шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах.**

**27<sup>1</sup>.1.7.шаардлагатай тохиолдолд төрийн байгууллага, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох.**

**27<sup>1</sup>.2.Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн 27<sup>1</sup>.1.1-27<sup>1</sup>.1.7-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.**

**27<sup>1</sup>.3.Онцгой комиссын шийдвэр, тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сахин мөрдөхийг хамрах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнээс шаардана.**

**27<sup>1</sup>.4.Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ.**

**27<sup>1</sup>.5.Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.**

**27<sup>1</sup>.6.Улсын онцгой комисс нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудастай байна.**

**28 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

28.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх;

~~28.1.2.улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үссэн буюу үснэ болзошгүй гамшгийн үед онд оржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;~~

28.1.3.гамшгийн нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих;

28.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, бараа, материал, тоног төхөөрөмжийг улсын нөөцөөс гаргах асуудлыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, удирдамжийг батлах;

28.1.6.гамшгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээллэх;

28.1.7.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.8.гамшигийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.9.онцгой байдлын байгууллагыг хөгжүүлэх бодлого болон түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.10.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх.

**28.1.11.гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсвийн төслийг Засгийн газарт оруулж батлуулах.**

**29 дүгээр зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

29.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүрэгтэй:

29.1.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих;

29.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

29.1.3.өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;

29.1.4.орон нутгийн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих;

29.1.5.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах;

29.1.6.шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшигийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

29.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

29.1.8.гамшигийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардал, нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

29.1.9.Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусlamжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

29.1.10.гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;

29.1.11.гамшигийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх;

29.1.12.гамшигийн **судалгаа, шинжилгээ хийх** мэдээллийн сан байгуулах, ашиглах;

29.1.13.гамшигаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах;

29.1.14.гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

29.1.15.гамшигаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

29.1.16.гамшигаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

29.1.17.гамшигаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, **мэргэжлийн дэмжлэг үзүүлэх**;

29.1.18.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

29.1.19.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

### **30 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх**

30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т заасан бүрэн эрхээс гадна доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.гамшигаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах;

30.1.2.гамшигаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлан гаргах, хуваарилах, оролцуулах;

30.1.3.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг чиглүүлэх;

30.1.4.гамшигаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх;

30.1.5.гамшигаас хамгаалах бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;

30.1.6.гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шуурхай мэдээлэх;

30.1.7.гамшигаас хамгаалах харилцан ажиллагааны төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран батлах;

30.1.8.онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

30.1.9.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тооног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хангамжийн талаархи бодлогыг боловсруулж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах, шийдвэрлүүлэх;

30.1.10.хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах;

30.1.11.онцгой байдлын байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

30.1.12.онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах;

30.1.13.онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

**30.1.14.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бутцийн нэгж, харьяа салбар, нэгжийн бутэц, орон тоо, цалингийн санг тогтоох, алба хаагч болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх;**

30.1.15.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу цэргийн цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх, сахилга, ёс зүйн хариуцлага хүлээлгэх;

30.1.16.төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

30.1.17.үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг зэвсэгт хүчиний ерөнхий командлагчид шууд танилцуулан шийдвэрлүүлэх;

**30.1.18.Улсын нөөц, хүмүүнлэгийн тусlamжийг бүрдүүлэх, хадгалах, хуваарилах, хяналт тавих, аюулгүй байдлыг хангах.**

30.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга энэ хуулийн 30.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

30.3.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

**30.4.Онцгой байдлын байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах эрхээ харьяа санхүүгийн нэгжийн дарга, эсхүл энэ хуулийн 42.6-д заасан албан тушаалтанд шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.**

## **31 дүгээр зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх**

31.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих;

31.1.2.гамшигаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи Засаг даргын мэдээллийг сонсох, тайланг хэлэлцэх, чиглэл өгөх;

31.1.3.гамшигийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг хуулийн дагуу батлах.

## **32 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх**

32.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшигаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшигаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх;

32.1.2.нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшигийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;

32.1.3.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшигаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бурдүүлэх, түүнийг захиран зарцуулах;

32.1.4.гамшигийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах;

32.1.5.хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах;

32.1.6.нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

32.1.7.гамшигийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;

32.1.8.гамшигаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

32.1.9.гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах;

32.1.10.орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;

32.1.11.харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах;

32.1.12.гамшигийн эрсдэлийн болон гамшигийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

32.1.13.тухайн шатны Засаг дарга нь төв, орон нутагт томилогдон ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх.

**32.1.14.онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, суурин газарт гамшигаас хамгаалах асуудлыг Засаг даргын тамгын газрын аль нэг албан тушаалтанд хавсрсан гүйцэтгүүлнэ.**

32.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### **33 дугаар зүйл. Гамшигаас хамгаалах албаны чиг үүрэг**

33.1.Гамшигаас хамгаалах улсын алба дараахь чиг үүрэгтэй:

33.1.1.салбарын хэмжээнд гамшигаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

33.1.2.салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтэд гамшигийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;

33.1.3.хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

33.1.4.салбарын онцлогт нийцүүлэн гамшигаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

33.1.5.гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах;

33.1.6.салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;

33.1.7.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшигийн нөөцийг бүрдүүлэх;

33.1.8.орон нутгийн гамшигаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

33.1.9.гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;

33.1.10.голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах;

33.1.11.хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

33.1.12.гамшигийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

33.1.13.гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаархи мэдээ, тайлан гаргах.

**33.1.14.хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж, батлуулах.**

33.2.Гамшигаас хамгаалах улсын алба нь гамшигаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байна.

33.3.Орон нутгийн гамшигаас хамгаалах алба энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

**34 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн эрх, үүрэг**

34.1.Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшигаас хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ:

34.1.1.гамшигаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;

34.1.2.гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах.

34.2.Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшигаас хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

34.2.1.гамшигаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

34.2.2.гамшигаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

34.2.3.үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, **зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх**;

34.2.4.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

34.2.5.гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;

34.2.6.гамшигаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах;

34.2.7.гамшигаас хамгаалах үйл ажиллагаа, гамшиг болон аюулын нөхцөл байдлын тухай мэдээг дээд шатны байгууллага болон онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай бичиг баримт, бодит мэдээллээр хангах;

34.2.8.гамшиг, **гамшигийн онцгой нөхцөл байдал** болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргodoх байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;

34.2.9.гамшигийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

**34.2.10.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөн, гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас учирсан хохирол, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хариуцах.**

**35 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын эрх, үүрэг**

35.1.Төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараах эрх, үүрэгтэй оролцно:

35.1.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд иргэний хяналт тавих;

35.1.2.гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль тогтоомж, зөвлөмж, арга зүй боловсруулахад оролцох;

35.1.3.гамшгаас хамгаалах судалгаа, сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

35.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн, сайн дурын хэсэг, бүлэг, нөхөрлөлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

35.1.5.онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах.

## **36 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг**

36.1.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг дараах эрх, үүрэгтэй:

36.1.1.гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах;

36.1.2.гамшгийн үеийн үйл ажиллагаанд оролцоход шаардагдах багаж, хэрэгсэл, хүнсээр хангагдах;

36.1.3.онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшуулал авах;

36.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг биелүүлэх;

36.1.5.гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад үнэн зөв, бодит, шуурхай мэдээлэл өгөх;

36.1.6.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж оролцох.

36.2.Сайн дурын хэсгийн ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүнд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ахлагчийн албан тушаалын зэрэглэлийн анхны шатлалын үндсэн цалингаар тооцон 2 жилийн, амь насаа алдсан бол түүний гэр бүлд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

36.3.Сайн дурын хэсэг нь тухайн шатны Засаг даргад гамшгаас хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлagnана.

36.4.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **37 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг**

37.1.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ:

37.1.1.холбогдох байгууллага, албан тушаалтнаас аюулгүй байдлаа хангахад шаардлагатай арга хэмжээний талаар үнэн зөв мэдээлэл авах;

37.1.2.гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшигаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх;

37.1.3.гамшигт өртсөн тохиолдолд шаардлагатай тусламж, дэмжлэг авах;

37.1.4.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлагдан оролцох үед хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан бол энэ хуулийн 36.2-т заасан тусламж авах;

37.1.5.голомтын бүсэд дайчлагдан үндсэн ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэсэн бол цалин хөлсөө ажил олгогчоос, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адил томилотын зардлыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр авах.

37.2.Иргэн гамшигаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

37.2.1.гамшигаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

37.2.2.гамшигаас хамгаалах сургалтад оролцох;

37.2.3.өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах;

37.2.4.гамшиг болон аюулаас урьдчилан сэргийлэх, аврах арга, техник, багаж хэрэгслийг эзэмших, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх;

37.2.5.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

37.2.6.гамшиг болон аюулын тухай мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв хүргэх;

37.2.7.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөн, гамшигаас хамгаалах болон гол түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардал, учирсан хохирол, хуурамч дуудлага өгсөний улмаас гарсан зардлыг нөхөн төлөх;

**37.2.8.хорио цээр болон хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичигтэй зорчих.**

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ**

### **38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж**

38.1.Гамшигаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.

### **39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж**

39.1.Гамшигийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Улсын онцгой комисс олон улсын хүмүүнлэгийн тусламж авах саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

39.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид “тусламж үзүүлэгч тал” гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусlamж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусlamжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.

39.3.Тусlamж үзүүлэгч тал нь тухайн улсын болон олон улсын байгууллагад бүртгүүлсэн байна.

39.4.Монголын улаан загалмай нийгэмлэг нь олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусlamж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

#### **40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусlamжийн зохицуулалт**

40.1.Олон улсын хүмүүнлэгийн тусlamжийг бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомж, заавар, удирдамжийн дагуу Улсын онцгой комисс зохицуулж, хяналт тавина.

40.2.Олон улсын хүмүүнлэгийн тусlamжийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

40.3.Тусlamж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.4.Тусlamж үзүүлэгч тал дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

40.4.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;

40.4.2.хувь хүний нууцыг задруулах;

40.4.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдолгүй асуудалд оролцох, улс төрийн болон шашин шүтлэгийн байр суурийг илэрхийлэх;

40.4.4.санхүүгийн ашиг сонирхол хайх;

40.4.5.хүмүүнлэгийн тусlamжтай хамааралгүй асуудлаар мэдээлэл цуглуулах;

40.4.6.олон улсын байгууллага болон гадаад улсын Засгийн газрын бодлогыг тулгах.

40.5.Тусlamж үзүүлэгч талын бараа, үйлчилгээ нь Монгол Улсын хууль тогтоомж, нэрвэгдэгсдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

40.6.Тусlamж үзүүлэгч тал нь бараа, үйлчилгээ, тооног төхөөрөмжийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ашиглахгүй болох, аюултай хог, хаягдал үүсгэх тохиолдолд дахин боловсруулж ашиглах, эсхүл байгаль орчинд ээлтэй аргаар устгах ажиллагааг холбогдох байгууллагын хяналтын доор өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

40.7.Тусlamж үзүүлэгч талын мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусlamжийг хүлээн авах эсэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

40.8.Олон улсын хүмүүнлэгийн тусlamжийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Улсын онцгой комисс Засгийн газарт тайлagnана.

## **41 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусlamжийг зогсоох**

41.1.Улсын онцгой комиссын саналыг үндэслэн Засгийн газар тусlamж үзүүлэгч талын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг гаргана.

41.2.Засгийн газар олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагааг зогсоохоор бол энэ тухай шийдвэрийг тусlamж үзүүлэгч талд 30 хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.

41.3.Тусlamж үзүүлэгч тал нь энэ хуулийн 40.4-д заасан үйл ажиллагааг явуулсан нь тогтоогдвол Засгийн газрын шийдвэрээр тусlamжийн үйл ажиллагааг шууд зогсоно.

## **ЕСДҮГЭР БҮЛЭГ ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

### **42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо**

42.1.Онцгой байдлын байгууллага нь гамшигаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшигаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

42.2.Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бусийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилаа байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт-үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.

42.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

**42.4.1.энэ хуулийн 42.4-т заасан төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд байгуулсан онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагааны бүх зардлыг тухайн байгууллага бүрэн хариуцна.**

42.5.Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

**42.6.Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.**

**42.7.Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан Онцгой байдлын байгууллагын гамшигаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.**

**42.8.Онцгой байдлын байгууллагын бусийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.**

**42.9.Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн бие бүрэлдэхүүний тоо, техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно.**

#### **43 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг**

43.1.Онцгой байдлын байгууллага нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.

43.2.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

43.3.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийг тус байгууллагаас бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэн хэрэглэхийг хориглоно.

#### **44 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг**

44.1.Онцгой байдлын байгууллага нь дараахь үндсэн чиг үүрэгтэй:

44.1.1.гамшигаас урьдчилан сэргийлэх;

44.1.2.гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах;

44.1.3.гамшигийн хор уршгийг арилгах;

44.1.4.хойшлуулшгүй сэргээн босгох.

**44.1.5.улсын нөөц, хүмүүнлэгийн тусlamжийг зохион байгуулах.**

#### **45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагч**

45.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон Цэргийн албаны тухай хуульд заасан шаардлага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг авч ажиллуулна.

45.2.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.

45.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарна.

45.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд **15-аас** доошгүй жил, удирдах албан тушаалд **10-аас** доошгүй жил ажилласан алба хаагчийг томилно.

**45.5.Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрхзүйн баталгаагаар хангагдана.**

#### **46 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг**

46.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

46.2.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тэргүүн **дэд дарга**, дэд даргад цэргийн дээд цол олгож болно.

**46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.**

46.4.Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.5.Онцгой байдлын байгууллагад цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.

**46.6.Онцгой байдлын байгууллагын дүрэмт хувцсыг иргэн, хуулийн этгээд, байгууллага хэрэглэхийг хориглоно.**

#### **47 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх**

47.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараах эрх эдэлнэ:

47.1.1.гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;

47.1.2.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх.

#### **48 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг**

48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;

48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

**48.2.Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.**

**48.3.Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан нь гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.**

**49 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж**

49.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авна.

49.2.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.

49.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

**50 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа**

50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно /**дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно/**.

50.2.Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

50.3.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.

50.4.Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химиин хортой болон аюултай бодис, далд уурхай, **ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.**

50.5.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.

50.6.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

50.9.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн **30** хувиас доошгүй байна.

**50.10.Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон**

**ажиллуулвал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх нэмэгдлийг улирал тутамд олгоно.**

**50.11. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.**

**50.12. Энэ хуулийн 50.10-т заасан нэмэгдэл, 50.11-д заасан нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.**

**50.13. Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцно.**

### **АРАВДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ**

#### **51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт**

**51.1. Төсвийн өрөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.**

**51.2. Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувиас доошгүйгээр тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.**

**51.3. Аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна.**

**51.4. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.**

### **АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **52 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

**52.1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол **Төрийн албаны тухай хууль**, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**Тайлбар: Шинээр нэмсэн зүйл, хэсэг, заалтыг “**Bold**”-оор, өөрчлөн найруулсан хэсэг, заалтыг “**Underline**”-аар, хүчингүй болгосон хэсэг, заалтыг “**Strikethrougt**”-аар тэмдэглэв.**